

# “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ”


## 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭЛЭЛ

### Нэг. Автотээврийн хэрэгслийн мэдээлэл

/Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сан/

#### 1.1 Тээврийн хэрэгслийн бүртгэлин үйл ажиллагаа:

Улсын хэмжээнд 2023.11.30-ний өдрийн байдлаар нийслэлд 692,453 /58,6%/, орон нутагт 488,979 /41,4 %/ нийт 1,181,432 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.




#### Шинээр бүртгэсэн тээврийн хэрэгсэл

Тайлант хугацаанд нийт 105,502 тээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн. 2022 оны мөн үеийнхээс 14,682 тээврийн хэрэгсэл буюу 16.1%-иар өссөн дүнтэй байна.




#### Шилжилт хөдөлгөөн

2023 оны эхний хагас жилд нийт 585,922 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн өөрчлөлтийг бүртгэсэн. 2022 оны мөн үеийнхээс 104,567 тээврийн хэрэгсэл буюу 21 %-иар өссөн дүнтэй байна.




Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олголт

Нийт 23,972 тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгосон байна. 2022 оны мөн үеийнхээс 9,013 тээврийн хэрэгсэл буюу 60%-иар өссөн дүнтэй байна.



Орон нутаг дахь бүртгэлийг аймгуудаар харуулвал:

Тайлант хугацаанд орон нутгийн 21 аймгийн 23 салбарт импортын бүртгэл 6,912 шилжилт хөдөлгөөн, өөрчлөлт бүртгүүлсэн 130,181 нийт 137,093 автотээврийн хэрэгслийн бүртгэл хийгдэж гэрчилгээ олгогдсон.



Төрөл	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Сэлэнгэ	Сүхбаатар
Суудал	11744	15992	13082	8683	9016	2686	20197	14026	12939	7585	10034	23568	16776	9572
Ачаа	7625	4531	4174	5401	3138	793	5273	3890	4883	3772	5828	4503	8939	4918
Автобус	315	917	668	176	604	82	380	744	475	334	425	589	348	282
Тусгай	108	202	204	83	91	60	213	230	161	121	122	244	191	64
Цистерн	13	55	47	28	22	43	95	104	84	30	46	87	56	27
Зүтгүүр	86	134	104	13	53	63	128	3164	271	31	40	124	229	810
Механизм	77	130	148	100	77	54	619	224	224	84	85	378	602	44
Чиргүүл	197	302	181	91	118	106	357	3333	416	57	151	300	476	924
Мотоцикл	424	2800	1274	764	1686	194	433	472	1285	1750	943	488	1366	666
<b>Нийт</b>	<b>20589</b>	<b>25063</b>	<b>19882</b>	<b>15339</b>	<b>14805</b>	<b>4081</b>	<b>27695</b>	<b>26187</b>	<b>20738</b>	<b>13764</b>	<b>17674</b>	<b>30281</b>	<b>28983</b>	<b>17307</b>
Баруун	11647	11118	11800	8030	7768	2390	17601	11275	12311	7060	9024	19985	14881	9221
Зүүн	8244	10729	6480	6355	5157	1337	8682	10883	6502	4815	7470	9133	11659	6453
<b>Нийт</b>	<b>19891</b>	<b>21847</b>	<b>18280</b>	<b>14385</b>	<b>12925</b>	<b>3727</b>	<b>26283</b>	<b>22158</b>	<b>18813</b>	<b>11875</b>	<b>16494</b>	<b>29118</b>	<b>26540</b>	<b>15674</b>
Бензин	7200	16973	9652	6162	6720	1758	9806	8462	7108	6186	7416	12207	11548	4840
Дизель	8276	4503	5336	5855	4576	1061	6678	8185	6353	4146	6949	6221	9851	6427
Цахилгаан	3	0	7	1	0	0	15	2	4	4	0	9	2	6
Газ	94	125	105	251	45	89	989	360	95	149	73	936	665	68
Хосолсон	4803	3149	4583	2960	3335	1059	9799	5761	6658	3164	3060	10563	6363	5015
<b>Нийт</b>	<b>20376</b>	<b>24750</b>	<b>19683</b>	<b>15229</b>	<b>14676</b>	<b>3967</b>	<b>27287</b>	<b>22770</b>	<b>20218</b>	<b>13649</b>	<b>17498</b>	<b>29936</b>	<b>28429</b>	<b>16356</b>
0-3	306	1162	508	287	629	133	625	1063	602	509	327	606	716	634
4-6	379	1154	829	509	880	171	550	743	851	1096	559	684	721	724
7-9	1272	1201	1341	1202	1093	389	2800	2450	1747	1177	1153	3333	2219	1431
10 ба түүнээс дээш	18632	21546	17204	13341	12203	3388	23720	21931	17538	10982	15635	25658	25327	14518
<b>Нийт</b>	<b>20589</b>	<b>25063</b>	<b>19882</b>	<b>15339</b>	<b>14805</b>	<b>4081</b>	<b>27695</b>	<b>26187</b>	<b>20738</b>	<b>13764</b>	<b>17674</b>	<b>30281</b>	<b>28983</b>	<b>17307</b>
1500 см3 хүртэл	7028	9398	7934	5580	6189	1450	8210	6187	8371	6143	6222	9520	8930	6423
1501-2500 см3	8831	8709	7083	6605	4636	1697	13433	8505	8060	4745	6568	13302	12888	5886
2501-3500 см3	3142	3356	2820	2117	2663	429	2870	3098	2152	1935	2877	4052	3327	2343
3501-4500 см3	649	1082	767	425	659	101	698	704	537	431	909	959	825	427
4501 см3 дээш	721	2170	1073	496	522	288	1988	4313	1169	430	930	2095	2439	1283
<b>Нийт</b>	<b>20371</b>	<b>24715</b>	<b>19677</b>	<b>15223</b>	<b>14669</b>	<b>3965</b>	<b>27199</b>	<b>22807</b>	<b>20289</b>	<b>13684</b>	<b>17506</b>	<b>29928</b>	<b>28409</b>	<b>16362</b>

Төв	Улаанбаатар	Увс	Ховд	Хэнтий	Хөвсгөл	Өвөрхангай	Өмнөговь	Нийт
11309	502408	12302	13577	12149	19208	16108	18298	781259
7704	83109	4891	4784	5726	8793	7207	5284	195166
291	12552	529	593	425	1050	559	1082	23420
118	6883	143	156	121	258	134	551	10458
62	2908	38	45	34	73	39	209	4145
44	26223	74	1622	59	180	280	14096	47828
334	11824	142	169	142	175	258	931	16821
159	38841	173	1636	244	362	588	21760	70772
943	7705	2947	1045	784	1145	1706	743	31563
<b>20964</b>	<b>692453</b>	<b>21239</b>	<b>23627</b>	<b>19684</b>	<b>31244</b>	<b>26879</b>	<b>62954</b>	<b>1181432</b>
10905	435490	10992	11680	11478	17572	15399	16436	684063
8623	198605	6989	9096	7034	11992	8928	23087	378253
<b>19528</b>	<b>634095</b>	<b>17981</b>	<b>20776</b>	<b>18512</b>	<b>29564</b>	<b>24327</b>	<b>39523</b>	<b>1062316</b>
7755	231684	11303	8834	7799	13513	10893	11740	419559
8531	147664	5831	7785	6731	10338	8920	22945	303162
1	939	0	1	9	3	1	23	1030
226	8240	49	68	130	294	177	122	13350
4239	263556	3853	5257	4740	6704	6256	6315	371192
<b>20752</b>	<b>652083</b>	<b>21036</b>	<b>21945</b>	<b>19409</b>	<b>30852</b>	<b>26247</b>	<b>41145</b>	<b>1108293</b>
388	49947	1256	1028	427	857	756	20485	83251
737	26792	1489	933	730	533	1304	3428	45796
1531	105950	1771	1947	1733	1614	1724	2898	141976
18308	509765	16723	19719	16794	28240	23095	36143	910410
<b>20964</b>	<b>692454</b>	<b>21239</b>	<b>23627</b>	<b>19684</b>	<b>31244</b>	<b>26879</b>	<b>62954</b>	<b>1181433</b>
7205	189338	9218	8856	7889	11500	10415	8270	350276
9272	274033	6582	7020	7218	11075	10262	9756	446166
2819	82043	3193	2635	2708	5180	3238	3789	142786
566	28338	875	838	749	1501	793	2307	45140
864	77188	1163	2609	847	1589	1545	16922	122644
<b>20726</b>	<b>650940</b>	<b>21031</b>	<b>21958</b>	<b>19411</b>	<b>30845</b>	<b>26253</b>	<b>41044</b>	<b>1107012</b>

## **1.2 Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг:**


Улсын хэмжээнд 2023.11.30-ний өдрийн байдлаар 829,410 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна.




**Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийг насжилтаар нь ангилбал:**



**Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн төрлөөр нь ангилбал**



**Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийг төрлөөр нь ангилбал**



**Хоёр. Автозамын нөхцөл байдлын мэдээлэл**

Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутагтай, дэлхийд газар нутгийнхаа хэмжээгээр 19-д жагсдаг. Монгол Улсад авто замын дэд бүтэц нийт нутгийг хамран төдийлэн сайн хөгжөөгүй тул замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Монгол Улсын авто замын сүлжээ нь

олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 111 916.7 км авто замаас бүрддэг. Нийт авто замын сүлжээнээс 4 299.3 км авто зам нь олон улсын, 14 921.3 км нь улсын чанартай авто замд хамаарагдах бөгөөд үүний 7485.6 км нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 898.4 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32/, Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4a, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1a, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 3 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан. Монгол Улс авто замын сүлжээгээ өргөтгөн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, тэргүүн ээлжинд олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх зорилт тавин, энэ хүрээнд Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 чиглэлийн авто замын сүлжээнд хамаарах Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам буюу Ярант-Ховд-Өлгий-Улаан байшинт чиглэлийн авто замыг хөгжүүлэх, бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтыг авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 онд 21 аймаг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг баталж “Нутгийн зам” дэд хөтөлбөр батлан суурин газрыг хатуу хучилттай замаар холбох ажлыг хэрэгжүүлж эхэлснээр нийт 104 сумыг хатуу хучилттай авто замаар холбох ажил хийгдээд байна.

Сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хатуу хучилттай авто замын сүлжээний урт нэмэгдэж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдэж байна. Гэвч баригдсан авто замын сүлжээний ашиглалтын хугацаа уртсаж, норм нормативын дагуу зайлшгүй хийгдэх арчлалт, засварын ажил шаардлагын хэмжээнд хийгдэж чадахгүй байгаагаас авто замд ихээхэн эвдрэл гарч аюулгүй зорчих нөхцлийг хангаж чадахгүйд хүрч байна. /Нийт авто замын хучилтын байдал. Хүснэгт 1/

Улсын чанартай авто замын хучилтын байдал. Хүснэгт 1.

Улсын чанартай авто замын хучилтын төрөл		Авто замын урт /км/
а/ Хатуу хучилттай		7485.6
Үүнээс:	Цемент бетон	8.6
	Асфальт бетон	7 477,0
б/ Хайрган хучилттай		905.7
в/ Сайжруулсан хөрсөн		347.3
г/ Ердийн хөрсөн зам		6 182.7
<b>НИЙТ</b>		<b>14 921.3</b>

Улсын чанартай авто замд ашиглаж байгаа гүүрийн хэмжээ. Хүснэгт 2.

Гүүрүүд	Нийт /ш/	Нийт урт/метр
---------	----------	---------------

А: Улсын чанартай замд			
Үүнээс:	Төмөр бетон гүүр	317	14769.57
	Ган гүүр	1	284.0
	Модон гүүр	56	1057.7
Нийт		374	16 111.27

Улсын чанартай авто замын сүлжээ. Зураг 1.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн хүчин зүйлийн нэг бол авто замын сүлжээнд аюулгүй зорчих ашиглалтын бэлэн байдлыг хангах асуудал юм. Бэлэн байдлыг хангахад авто замын насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ чухал нөлөөтэй байдаг. /Авто замын насжилтын байдал. Хүснэгт 3./

Авто замын насжилт. Хүснэгт 3.

№	Хатуу хучилттай авто замын насжилт, жил	Урт, км	Эзлэх хувь, %
1	6 жил хүртэл	1264.1	16.9
2	6-13 жил	4227.8	56.5
3	13-аас дээш жил	1993.7	26.6
Нийт		7485.6	100

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалгаалан авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагатай засвар арчлалтыг хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалт норм, нормативын хэмжээнд хийгдэж чадахгүй байна.

Тухайлбал олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын түвшинг бууруулахгүйгээр байнгын бэлэн байдлыг хангахад нормативын дагуу жилд урсгал засвар болон арчлалтад 113 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай боловч жил бүр улсын төсвийн хөрөнгөөс нийт шаардагдах хөрөнгийн дөнгөж 30-50 хувь шийдвэрлэж байна. Энэ нь жил ирэх тутам

засвар, арчлалт бүрэн хийгдэхгүй байгаагаас замын ашиглалтын бэлэн байдлыг хангахад хүндрэлтэй болж байна. /Урсгал засвар, арчлалтын хөрөнгө оруулалт 2016-2023 он. Хүснэгт 4/



Авто замын салбарт 2023 онд засвар арчлалтын ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр 7 байршилд 56.2 км авто замын их засварын ажил хийгдэж, ажлын гүйцэтгэл 100%-тай, АХБ-ны санхүүжилтээр 57.56 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажил хийгдэж, ажлын гүйцэтгэл 100%-тай дууссан байна. Ээлжит засварын ажлын хүрээнд Налайх-Тэрэлж, Ховд-Өлгий, Өндөрхаан-Чойбалсан, Хархорин-Цэцэрлэг, Улаанбаатар-Өндөрхаан, Улаанбаатар-Арвайхээр, Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн нийт 72.3 км авто замын ажил хийгдэж, нийт ажлын гүйцэтгэл 100%-тай 2023 оны ажил дууссан. Мөн Улсын чанартай 14 921.3 км авто замын засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 100%-тай хэрэгжиж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зам, тээврийн хөгжлийн яамтай 2023 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт 755.1 км авто замын барилга угсралтын ажил, 230 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил, гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр нийт 261.5 км авто замын барилга угсралтын ажил, мөн 201.08 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил, Төр хувийн хэвшлийн түншлэлээр буюу концессын гэрээгээр нийт 1237.5 км авто замын барилгын ажил хийгдэж байна.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгуулагууд /UNESCAP, CAREC зэрэг/ нь бүс нутгаараа хамтран эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх зорилгод бүс нутгийг дамнасан авто замын коридоруудыг хөгжүүлэх зорилт тавьсан бөгөөд



Баруун босоо, Хэвтээ тэнхлэгийн коридорын дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги, бодлого, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

### **Гурав. Жолооч нар болон сургалтын байгууллагын мэдээлэл**

#### **3.1. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын сонсогчдоос шалгалт авах чиглэлээр:**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”-ын дагуу давхардсан тоогоор 9020 шалгуулагчаас замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 5506 буюу 61.0 хувь, 6136 шалгуулагчаас замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт авснаас 4481 буюу 73.0 хувь, 3260 шалгуулагчаас талбайн жолоодлогын шалгалт авснаас 2686 буюу 82.3 хувь нь тэнцсэн байна.

Д/д	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт									Шинээр жолоодох эрх	Ангилал нэмсэн	Жолоодох эрхийн үнэмлэх нөхөн олгосон	Олон улсын жолоодох	Гадаад улсын жолоодох	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан		Тээврийн хэрэгсэл жолоодох эрх, зөрчлийн оноо нэмсэн		Нийт хэвлэгдсэн үнэмлэх
1	Замын хөдөлгөөний хууль, дүрэм			Замын хөдөлгөөний жолоодлого			Тусгай талбайн жолоодлого								Зөрчлийн тухай хуулиар	Эрүүгийн хуулиар	Жолоодох эрх сэргээсэн	Оноо нэмсэн	
2	Шалгагдсан	Тэнцсэн	Хувь	Шалгагдсан	Тэнцсэн	Хувь	Шалгагдсан	Тэнцсэн	Хувь										
3	9020	5506	61,0%	6136	4481	73,0%	3260	2686	82,3%	4683	2589	1840	242	155	3343	65	3390	9020	5506

#### **3.2 Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагууд**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2, 14.6 дугаар зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дугаар заалтыг тус тус үндэслэн, тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага MNS6585:2016 стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирлын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/270 дугаар тушаалаар байгуулагдсан хяналт үнэлгээний багийн ажлын

хэсэг 2023 оны 11 дүгээр сард жолооны мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн хамт тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх 18, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын 10, нийт 28 байгууллагад хяналт үнэлгээ хийсэн.

2023 оны 11 дугаар сарын 1-10 хооронд нийт 28 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын хүсэлт ирснээс:

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төв

- Шинээр **2** байгууллага
- Сунгуулсан **4** байгууллага
- Ангилал болон тээврийн хэрэгсэл нэмүүлсэн **4**
- Өөрийн хүсэлтээр хойшлуулсан **1**
- Шаардлага хангаагүй буюу түр түдгэлзүүлсэн **7**

Мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын төв

- Сунгуулсан **9**
- Шаардлага хангаагүй буюу түр түдгэлзүүлсэн **1**

**НИЙТ СУРГАЛТЫН ТӨВ** /2023 оны 11 сарын байдлаар/

- **Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төв**  
Улаанбаатар хот-164  
Орон нутаг-194  
Салбар сургууль-76
- **Мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын төв**  
Улаанбаатар хот-19  
Орон нутаг-22

### 3.3 Мэргэшсэн жолооч бэлтгэх үйл ажиллагаа:

2023 оны 10 дугаар сард 1539 жолоочоос давхардсан тоогоор 3277 удаа ангилал бүрээр шалгалт авч 1753 тэнцсэн.

Шалгалт ангилал тус бүрээр:

№	Ангилал	Шинээр		Сунгалт	
		Орсон	Тэнцсэн	Орсон	Тэнцсэн
1	В	89	36	127	62
2	С	103	60	62	34
3	Д	220	86	194	110
4	Е	1007	432	341	204
5	УХАТ	777	466	141	117
6	УХЗТ	45	26	10	10

7	ЖУУ	45	32	10	10
8	АА	96	59	10	9

### **Дөрөв. Зам, тээврийн осол, хэргийн нөхцөл байдал**

Энэ оны эхний 11 сард цагдаагийн байгууллагад зам тээврийн ослын шинжтэй 103441 дуудлага мэдээлэл ирснээс 21876 зам тээврийн осол, хэрэг бүртгэгдэж, 525 хүний амь нас хохирч, 2847 хүн хүнд, хөнгөн хэлбэрээр гэмтсэн байна. Тайлангийн хугацаанд хүүхэд өртсөн зам тээврийн осол хэрэг 780 бүртгэгдэж, 55 хүүхдийн амь нас хохирсон харамсалтай тоо мэдээлэлтэй байна.

Зам, тээврийн осол, хэргийн тоо мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дуудлага, мэдээлэл 17,2 хувь, бүртгэгдсэн зам тээврийн осол 3,9 хувь, зам тээврийн осол, хэргийн улмаас гэмтсэн хүний тоо 5,6 хувь, зам тээврийн осол, хэргийн улмаас нас барсан хүний тоо 1,4 хувь, хүүхэд өртсөн зам тээврийн осол, хэрэг 8,2 хувь тус тус өссөн бол зам тээврийн осол, хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 19,1 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн 2,755,491 зөрчлийг илрүүлж, зөрчил үйлдсэн 2,654,768 жолоочийг 78,224,438,500 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Дээрх хугацаанд цагдаагийн нийтлэг үүрэг болон бусад хууль тогтоомж зөрчсөн зөрчил 1000, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 40357 зөрчил тус тус илрүүлж, 31264 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 7803 хүнийг баривчлах арга хэмжээ тооцсон байна.

№	Үзүүлэлт	Нийслэл		Орон нутаг		Улс		нийслэл өсөлт, бууралт	орон нутаг өсөлт, бууралт	улс өсөлт бууралт
		2022 оны эхний 11 сар	2023 оны эхний 11 сар	2022 оны эхний 11 сар	2023 оны эхний 11 сар	2022 оны эхний 11 сар	2023 оны эхний 11 сар			
1	Зам тээврийн ослын шинжтэй дуудлага	83071	96949	5183	6492	88254	103441	16.7	25.3	17.2
2	Бүртгэгдсэн зам тээврийн осол	17635	18098	3415	3778	21050	21876	2.6	10.6	3.9
3	Гэмт хэрэг	580	554	598	655	1178	1209	-4.5	9.5	2.6
	Үүнээс: согтуугаар үйлдэгдсэн	69	57	178	155	247	212	-17.4	-12.9	-14.2
4	Гэмт хэргийн улмаас нас барсан /статистик/	56	56	218	223	274	279	0.0	2.3	1.8
5	Бодит нас баралт	83	94	435	431	518	525	13.3	-0.9	1.4
6	Хэргийн улмаас гэмтсэн хүн	535	502	456	516	991	1018	-6.2	13.2	2.7


7	Гэмтсэн хүн /осол/	1624	1751	1073	1096	2697	2847	7.8	2.1	5.6
8	Хүүхэд өртсөн осол	410	439	311	341	721	780	7.1	9.6	8.2
	үүнээс нас барсан хүүхэд бодит	6	4	62	51	68	55	-33.3	-17.7	-19.1
9	Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол	28,486,097,848	31,969,128,961	8,928,245,695	15,197,474,695	37,414,343,543	47,166,603,656	12.2	70.2	26.1
10	үүнээс: нөхөн төлүүлсэн хохирол	27,174,941,748	29,959,438,431	7,970,597,604	13,312,007,160	35,145,539,352	43,271,445,591	10.2	67.0	23.1
11	Нийт илрүүлсэн зөрчил	1870521	1995077	539726	760414	2410247	2755491	6.7	40.9	14.3
12	ЦНУ болон бусад хууль тогтоомж зөрчсөн зөрчил	698	357	1332	643	2030	1000	-48.9	-51.7	-50.7
13	согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил	28915	19445	22697	20912	51612	40357	-32.8	-7.9	-21.8
	Жолоодох эрхтэй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн	26185	16481	17165	15665	43350	32146	-37.1	-8.7	-25.8
	Эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн	1929	1614	2868	2573	4797	4187	-16.3	-10.3	-12.7
	Эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн	801	1350	2664	2674	3465	4024	68.5	0.4	16.1
14	Жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон	2730	4544	5532	8563	8262	13107	66.4	54.8	58.6
15	Торгосон хүн	1659652	1992826	476588	661942	2136240	2654768	20.1	38.9	24.3
16	Торгуулийн мөнгөн дүн	52,678,080,000	53,342,485,500	22,099,514,115	24,881,953,000	74777594115	78224438500	1.3	12.6	4.6
17	Эрх хассан	25775	16309	17508	14955	43283	31264	-36.7	-14.6	-27.8
18	Баривчилсан	2897	2260	5164	5543	8061	7803	-22.0	7.3	-3.2
19	Зарлагдсан дугаар илрүүлэлт	188	111	64	157	252	268	-41.0	2.4᠐	6.3
20	АСАП илрүүлэлт	2378	2677	389	514	2767	3191	12.6	32.1	15.3
21	Бэлэн бус торгууль төлөлт	НИЙТ		төлсөн		төлөөгүй		29.5		
		2029822		598498		1431324				

## Тав. Эрүүл мэнд салбарын мэдээлэл


### **2023 оны эхний 11 сарын хугацаанд эрүүл мэндийн салбарт бүртгэгдсэн зам тээврийн ослын өвчлөл, нас баралтын мэдээлэл**

Энэ оны эхний 11 сарын хугацаанд зам тээврийн осолд өртсөний улмаас 22478 хүн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авсан байна. Ялангуяа зуны сар буюу 6, 7, 8 саруудад тохиолдлын тоо их байжээ.

**Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл бүртгэгдсэн сараар**



**Зам тээврийн осол, хүйсээр**




■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Зам тээврийн осолд өртсөн тохиолдлын 65.1%-ийг эрэгтэйчүүд, 34.9%-ийг эмэгтэйчүүд эзэлсэн байна.

Зам тээврийн ослын хамгийн их хувийг тохиолдлын тоогоор 10-19 нас болон 30-39 насныхан эзэлж байна.

**Зам тээврийн осол насны бүлгээр**



**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН**

**Тээврийн хэрэгслийн төрөл**


**Тохиолдлын тоо**

**Хувь**

Суудлын машинтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	8000	35.4%
Мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	3872	17.1%
Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	4650	21.0%
Морь тэмээ унаж явсан хүн унаж гэмтэх	3154	14.0%
Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	1884	8.1%
Ачааны машинтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	588	3.0%
Автобустай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	262	1.0%
Бусад болон тодорхойгүй тээврийн хэрэгслийн осол	68	0.4%

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл харьяаллаар харвал Төв аймаг 773 /3.4%/ болон Архангай 741 /3.3%/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Говьсүмбэр 132 /0.6%/ болон Орхон 155 /0.7%/ аймгууд хамгийн бага бүртгэгдсэн байна. Бүсээр авч үзэхэд Төвийн бүс тухайн шалтгаант өвчлөлийн тохиолдол өндөр байна.


**Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл харьяаллаар**




**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ**

Монгол улсад 2023 оны эхний 11 сарын байдлаар зам тээврийн ослын шалтгаант нас баралт 451 бүртгэгдсэн байна. Нийт тохиолдлын 15.3% буюу 69 нь 7 сард бүртгэгдсэн бөгөөд 1 сард тухайн шалтгааны нас баралт бусад саруудаас бага бүртгэгдсэн байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, сараар**




**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт хүйс, хувь**



Энэ оны эхний 11 сарын байдлаар зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 76% буюу дээрх шалтгааны улмаас нас барсан 10 хүн тутмын 7 нь эрэгтэйчүүд байжээ.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг насны бүлэг тус бүрээр тооцож үзэхэд 40-54 насанд бусад наснаас өндөр байна.


**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт насны бүлгээр**



2023 оны эхний 11 сард бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 35.7% буюу 161 нь суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж амь эрсдсэн байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралт бүртгэгдсэн харьяаллаар харвал Төв аймаг 39 /8.6%/ болон Дорноговь аймаг 31 /6.9%/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Орхон /0.7%/ болон Дундговь /1.1%/ аймгууд хамгийн бага бүртгэгдсэн байна. Бүсээр авч үзэхэд Төвийн бүсэд нас баралт хамгийн их тохиолджээ.





## Зургаа. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа


### 6.1 Жолоочийн даатгалын гэрээ, хураамжийн орлого

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниуд 2023 оны 11-р сард **57,420** жолоочийн даатгалын гэрээ байгуулж, **3,491,931,859** төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна. Даатгалын гэрээний хувьд ангиллаар авч үзвэл хувь хүний **39,608**, хуулийн этгээдийн **16,399**, мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн **860**, дамжин өнгөрөхийн **553** гэрээ тус тус байгуулагдсан байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоог доорх хүснэгт №1-ээс харна уу.

**Хүснэгт №1.** Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамжийн дүн өссөн дүнгээр

д/д	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн жолооч		Дамжин өнгөрөх		Нийт	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Миг даатгал	4,800	207,883,559	2,197	198,720,259	149	3,899,692	0	0	7,146	410,503,510
2	Мөнх даатгал	3,061	134,486,283	1,408	146,428,317	47	1,060,702	486	67,829,729	5,002	349,805,031
3	Монгол даатгал	4,280	179,299,183	1,762	183,984,185	84	2,059,528	60	9,494,359	6,186	374,837,255
4	Практикал даатгал	2,874	121,401,484	1,148	93,055,072	25	693,660	2	284,040	4,049	215,434,256
5	Амар даатгал	394	16,377,462	357	51,042,514	34	953,205	0	0	785	68,373,181
6	Улаанбаатар хотын даатгал	1688	76,159,948	406	36,053,235	5	82500	0	0	2099	112,295,683
7	Номин даатгал	5,482	244,990,228	1,658	148,315,441	71	1,760,019	1	237,006	7,212	395,302,694
8	Тэнгэр даатгал	1,168	62,945,188	622	62,490,795	54	1,420,732	1	277,992	1,845	127,134,707
9	Бодь даатгал	1026	37,269,309	366	36,139,410	34	792,000	2	293,436	1,428	74,494,155
10	Ган зам даатгал	3	231,615	27	2,996,370	9	255750	0	0	39	3,483,735
11	Монре даатгал	952	43,066,487	300	29,038,618	23	504,900	1	236,193	1276	72,846,198
12	Ард даатгал	12,058	590,579,353	3,657	352,247,364	153	4,039,530	0	0	15,868	946,866,247
13	Мандал даатгал	352	20,378,602	1,254	122,566,536	126	3,281,602	0	0	1,732	146,226,740
14	Хаан даатгал	939	38,026,460	1,001	86,943,951	32	976,222	0	0	1,972	125,946,633
15	Агула даатгал	531	40,787,692	236	26,977,207	14	616,935	0	0	781	68,381,834
	<b>Нийт</b>	<b>39,608</b>	<b>1,813,882,853</b>	<b>16,399</b>	<b>1,576,999,274</b>	<b>860</b>	<b>22,396,977</b>	<b>553</b>	<b>78,652,755</b>	<b>57,420</b>	<b>3,491,931,859</b>

**График №1. Жолоочийн даатгалын гэрээ /Даатгалын компаниар/**



**График №2. Жолоочийн даатгалын гэрээний хураамжийн харьцаа /гэрээний ангиллаар/**



Жолоочийн даатгалын гэрээг газар нутгийн байршлаар гэрээний тоо, хураамжийн хэмжээг хүснэгт №2-оос харна уу.

**Хүснэгт №2. Жолоочийн даатгалын гэрээ /газар нутгийн байршлаар/**

д/д	Байршил	Гэрээний тоо	Хураамжийн дүн
-----	---------	--------------	----------------

1	824	31,407,954	824
2	1105	37,192,259	1105
3	918	36,149,519	918
4	562	21,070,486	562
5	575	21,771,083	575
6	131	5,876,710	131
7	1,674	88,446,752	1,674
8	903	44,017,932	903
9	904	39,635,990	904
10	323	14,556,855	323
11	641	24,888,834	641
12	1,737	77,847,532	1,737
13	1,229	49,274,625	1,229
14	363	16,378,392	363
15	674	28,804,868	674
16	626	25,845,708	626
17	38,090	2,525,628,664	38,090
18	726	37,327,112	726
19	671	27,428,816	671
20	1010	39,545,448	1010
21	952	39,495,437	952
22	1,446	112,186,504	1,446
<b>Нийт</b>		<b>56,084</b>	<b>3,344,777,480</b>

*/\* Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тоо хураамжийн дүн ороогүй болно./*

2023 оны 10-р сард байгуулагдсан нийт гэрээний тоо, хураамжийн орлого болон цуцлалт

2023 оны 11-р сард гишүүн 15 даатгалын компаниуд нийт **58,177** даатгалын гэрээ байгуулж, **3,539,184,712** төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлж ажилласан байна. Үүнээс хувь хүний жолоочийн даатгалын **547** гэрээ, хуулийн этгээдийн **203** гэрээ, мэргэшсэн С, D ангиллын **4** гэрээ, дамжин өнгөрөх **3** даатгалын гэрээ цуцлагдсан байна. Нийт гэрээний **1,3%** буюу **757** гэрээ цуцлагдсан байна. Цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн **47,252,853** төгрөг байна.

**Хүснэгт №3.** Нийт гэрээний тоо, хураамжийн орлого

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн жолооч		/Дамжин өнгөрөх/		Нийт	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Миг даатгал	4,883	212,107,710	2,237	202,338,394	150	3,926,092	0	0	7,270	418,372,196
2	Мөнх даатгал	3,093	136,006,910	1,427	148,512,582	47	1,060,702	486	67,829,729	5,053	353,409,923
3	Монгол даатгал	4,358	182,851,946	1,799	187,052,735	86	2,112,080	63	9,857,530	6,306	381,874,291
4	Практикал даатгал	2,890	122,625,122	1,150	93,234,757	25	693,660	2	284,040	4,067	216,837,579

5	Амар даатгал	401	16,739,109	359	51,208,834	34	953,205	0	0	794	68,901,148
6	Улаанбаатар хотын даатгал	1711	77,417,026	412	36,627,255	5	82500	0	0	2128	114,126,781
7	Номин даатгал	5,582	249,593,994	1,671	149,187,721	71	1,760,019	1	237006	7,325	400,778,740
8	Тэнгэр даатгал	1,175	63,331,090	624	62,609,595	54	1,420,732	1	277992	1,854	127,639,409
9	Бодь даатгал	1038	37,800,485	373	36,751,905	34	792,000	2	293,436	1,447	75,637,826
10	Ган зам даатгал	3	231,615	27	2,996,370	9	255750	0	0	39	3,483,735
11	Монре даатгал	978	44,372,589	311	30,094,003	23	504,900	1	236193	1,313	75,207,685
12	Ард даатгал	12,177	596,960,583	3,686	355,239,256	154	4,056,030	0	0	16,017	956,255,869
13	Мандал даатгал	355	20,487,502	1,255	122,655,636	126	3,281,602	0	0	1,736	146,424,740
14	Хаан даатгал	962	39,101,214	1,027	89,286,741	32	976,222	0	0	2,021	129,364,177
15	Агула даатгал	549	42,234,676	244	28,019,002	14	616,935	0	0	807	70,870,613
	<b>Нийт</b>	<b>4,883</b>	<b>212,107,710</b>	<b>2,237</b>	<b>202,338,394</b>	<b>150</b>	<b>3,926,092</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>7,270</b>	<b>418,372,196</b>

*/Хүснэгт №1-ийн гэрээний тоо, хураамжийн орлогоос цуцлагдсан гэрээний тоо дүн ороогүй учир зөрүүтэй болно./*

## 6.2 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 5 даатгалын компани болон Холбооны даатгалын сангаас 2023 оны 11-р сард нийт **848** даатгалын тохиолдолд **1,025,787,356** төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрийн хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан **839** даатгалын тохиолдолд **1,008 сая** төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан **8** даатгалын тохиолдолд **10,3 сая** төгрөгийн нөхөн төлбөр, эрүүл мэндэд хохирол учруулсан **1** даатгалын тохиолдолд **7,8 сая** төгрөгийн нөхөн төлбөр тус тус олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг хүснэгт №4-өөс харна уу.

### **Хүснэгт №4. Нөхөн төлбөр /даатгалын компани тус бүрээр/**

д/д	Нэрс	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт	
		Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Миг даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Мөнх даатгал	88	119,164,040	-	-	-	-	1	7,780,000	89	126,944,040
3	Монгол даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Практикал даатгал	327	399,348,984	7	9,416,643	-	-	-	-	334	408,765,627
5	Амар даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Улаанбаатар хотын даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-

7	Номин даатгал	318	374,238,485	-	-	-	-	-	-	318	374,238,485
8	Тэнгэр даатгал	53	62,770,954	1	903,000	-	-	-	-	54	63,673,954
9	Бодь даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Ган зам даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Монре даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Ард даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Мандал даатгал	50	43,785,250	-	-	-	-	-	-	50	43,785,250
14	Хаан даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
15	Агула даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	АЖДХ	3	8,380,000	-	-	-	-	-	-	3	8,380,000
<b>Нийт</b>		<b>814</b>	<b>839</b>	<b>1,007,687,713</b>	<b>8</b>	<b>10,319,643</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>7,780,000</b>	<b>848</b>

**Хүснэгт №5.** Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

№	Хэмжээний интерваль	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	30	30	4,947,650
2	259	259	86,669,912
3	176	176	110,060,181
4	87	87	77,110,284
5	93	93	114,586,360
6	61	61	104,290,629
7	60	60	146,344,023
8	29	29	99,130,466
9	16	16	71,363,050
10	34	34	185,555,801
11	3	3	25,729,000
12	0	0	0
<b>Нийт</b>		<b>848</b>	<b>1,025,787,356</b>

**6.3 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдалт**

**Хүснэгт №6.** Жолоочийн даатгалд хамрагдалт

д/д	Үзүүлэлт	2023.10.01-2023.10.31
1	Даатгалын гэрээний тоо	57,420
2	Даатгалын хураамж /төг/	3,491,931,859
3	Нөхөн төлбөр авсан тоо	848
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	1,025,787,356
5	Дундаж хураамжийн дүн/төг/	60,814

#### 6.4 Даатгалын зуучлагч компани

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компаниас 2023 оны 11-р сард зуучлагч 29 компани **24,973** даатгалын гэрээ байгуулж, **1,5 тэрбум** төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

2023 оны 11-р сард нийт гэрээний тоонд эзлэх хувь **43%**, нийт хураамжийн дүнд эзлэх хувь **43%** байна.

#### **Хүснэгт №7. Жолоочийн даатгалын гэрээ /Зууч компаниар/**

№	Даатгалын зууч компани	Даатгалын гэрээ	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Профешнл иншурэнс партнер	2,606	155,791,557
2	Сүрэг хараацай	2,928	175,299,886
3	Смарт брокерс	1147	66,094,051
4	ХААН Банк	57	1,730,286
5	Лоялти Солюшн	431	24,958,041
6	Эрсдэлийн шийдэл	2137	130,436,860
7	Ачит-Ундарга	107	4,319,374
8	Төрийн банк	749	29,599,444
9	Дархан шаркс ХХК	1658	115,938,084
10	Монгол бичээч	86	7,384,295
11	Дэвжих дэлгэрэх	251	15,674,181
12	ХАС банк	32	2,003,983
13	МАСТЕР ШИЙДЭЛ	268	12,820,383
14	ХХБ	157	11,498,694
15	LBBrokerage ХХК	12	754,970
16	Си Эн Эн Икс	1895	113,068,899
17	Цагаан гэрэлт	964	57,927,987
18	Тод Капитал	946	51,719,147
19	Нэйшнл Эженси	641	76,332,977
20	МІВ	31	1,524,150
21	Эм Жи Ай Би ХХК	705	41,639,792
22	Амарди дижитал ХХК	888	55,267,194
23	Дэвжих зууч ХХК	1175	66,363,471
24	Ваясьню Солюшин ХХК	10	594,066
25	Асимон	2,201	102,707,151
26	Цахим капитал ХХК	1,404	90,039,061
27	ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК	4	210,038
28	НЭЙШНЛ ИНШУРАНС БРОКЕРЭЙЖ СЕРВИСЕС	6	349,387
29	Онч цэгц ХХК	1,477	93,260,055
<b>Нийт дүн</b>		<b>24,973</b>	<b>1,505,307,464</b>

#### **ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА**

2023 оны 11-р сард “В” ангиллын тээврийн хэрэгслийн гэрээ хамгийн их буюу **51,066** байгуулагдаж, **2,8 тэрбум** төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

**Хүснэгт №8.** Тээврийн хэрэгслийн ангиллаар

№	Зүйл /Ангилал/	Даатгалын гэрээний тоо	Даатгалын хураамжийн дүн
1	А	79	1,457,066
2	В	51,066	2,788,258,641
3	С	4,352	573,512,804
4	Д	792	97,768,908
5	М	270	8,500,437
6	Бусад		
	<b>Нийт</b>	<b>56,559</b>	<b>3,469,497,856</b>

*/\* Мэргэшсэн жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн ороогүй болно./\**

**Долоо. Татварын байгууллагын мэдээлэл**

Татварын ерөнхий газраас ЗХАБҮЗ-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон төлөлтийн мэдээлэл / 2023 /

**Татварын ерөнхий газраас ЗХАБҮЗ-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон төлөлтийн мэдээлэл / 9 сарын 20 - 10 сарын 20 хүртэл /**

Аймаг нэр	Татвар Төлөгчийн Тоо	Тээврийн хэрэгслийн тоо	АТБӨЯХАТ ногдол	АТБӨЯХАТ төлөлт	АБТ ногдол	АБТ төлөлт	АЗАТ ногдол	АЗАТ төлөлт
Архангай	77	77	1221198	626846	285000	70800	256979	246979
Багануур	30	35	524023	262223	90400	40600	251332	122065
Багахангай	3	3	27594	16457	3900	2100	23271	7336
Баянгол	725	1344	23844366.3	7231874.9	3388900	933400	23200903	4860755
Баянзүрх	952	1420	21552482.7	7516272.7	3781550	1170950	14054813	4507792.6
Баян-Өлгий	62	66	1222138	1018519	153715	90315	196731	196731
Баянхонгор	65	70	994211.04	575590.04	171150	58550	223532	208532
Булган	59	59	810548.96	458317.96	194800	50500	100000	100000
Говь-Алтай	55	56	782377	545734	172600	46500	185550	180000
Говьсүмбэр	23	23	277835	53471	108900	16100	8242	8242
Дархан-Уул	96	115	1872815.5	1044832.5	347600	162300	327463	297792
Дорноговь	89	95	2717246	2125094	274500	82000	243304	243304
Дорнод	69	79	1662832.9	1327596.9	232100	110800	511022	511022
Дундговь	47	48	730728.2	279057.2	173400	31700	92000	92000
Завхан	40	40	604413	391199	98000	19500	165000	165000

Налайх	53	55	895500	165225	158700	20100	477113	78493
Орхон	152	194	3211008.4	1844897.4	610099	233099	440522	440522
Өвөрхангай	100	116	2479049.5	1354691.5	280600	120000	768170	597920
Өмнөговь	108	177	8917777.21	5424938.8	512426	247426	499189.64	341189.6
Сонгино-хайрхан	568	793	13190373.8	5978805.9	2038683.3	764883.33	6175368.14	2483875.6
Сүхбаатар	49	58	1189093.5	532150.5	249000	49400	189171	171171
Сүхбаатар дүүрэг	815	1359	29404892.7	7252803.41	3843094.3	967394.35	26261573.65	4549264.6
Сэлэнгэ	71	77	965843	510254	301900	83000	193633	193633
Төв	68	68	852565.34	383659.34	350400	52500	156221	126188
Увс	54	57	1036530	580569	227700	72200	174396	174396
Хан-Уул	720	1225	36070048.5	14872486.2	3682300	1397700	21718228	5979278
Ховд	92	101	1571926.66	711013	409500	143000	304364	159614
Хөвсгөл	71	78	1271042.5	537793.5	362000	62300	241292	241292
Хэнтий	66	67	995175	341038	343900	51500	138683	118683
Чингэлтэй	359	750	20771781.4	9882669.4	2153715	660515	10799349.66	3772633.6
<b>Нийт дүн</b>	<b>5738</b>	<b>8705</b>	<b>181667417.6</b>	<b>73846080.6</b>	<b>25000532.6</b>	<b>7811132.68</b>	<b>108377416.1</b>	<b>31175704.2</b>

## **Найм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа**

### **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛОВ**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний Зөвлөлийн 2023 оны 2 дугаар хуралдаан Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот танхимд 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 15:00 цагт эхлэв.

Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх Жамбал даргалж, хуралдаанд Үндэсний Зөвлөлийн 14 гишүүдээс 10 гишүүн оролцож, 71,4 хувийн ирцтэйгээр хуралдав. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн гишүүд Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ҮЗ-ийн Ажлын албаны дарга Ё.Жаргалсайхан, Тээврийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Ц.Ариунболд, Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал М.Өлзийбат нараас гадна Ерөнхий сайдыг төлөөлж зөвлөх Б.Жамбал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргыг төлөөлж Ажлын албаны дарга Баярдорж, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж Засаг даргын зөвлөх бөгөөд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Ч.Батзориг, ЦЕГ-ын даргыг төлөөлж ТЦА-ны ЗЦГ-ын Зам, тээврийн



хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа М.Ариунболд, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийг төлөөлж менежер Л.Сэрээтэр нар оролцов. Мөн хэлэлцэж асуудуудтай холбоотойгоор ХНХЯ-ны ХНХСҮСИ-ийн захирал Б.Батбаатар, Агула даатгалын компани гүйцэтгэх захирал Д.Долгор, Повэред компани гүйцэтгэх захирал Р.Жавхлан болон холбогдох байгууллагуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.

Хуралдааныг Ерөнхий сайдын зөвлөх Б.Жамбал нээж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулав. Үүнд:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг аймаг орон нутагт зохион байгуулж байгаа ажлын тухай танилцуулга
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сангийн порталын хөгжүүлэлтийн тухай
3. Даатгалын үйлчилгээнд ухаалаг технологийн хөгжүүлэлтийн танилцуулга
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн явц
5. ЗХАБ ҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн санал
6. ЗХАБ-ын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх тухай

Хуралдаанаас хэлэлцүүлж байгаа асуудлаар тодорхой шийдвэрүүд гаргахаар төлөвлөж, төслийг Та бүхэнд урьдчилж өгсөн.

Хуралдааны хөтөлбөрт оруулах нэмэлт саналгүй бол хуралдааныг эхлүүлье.

**Ё.Жаргалсайхан:** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг аймаг орон нутагт зохион байгуулж байгаа ажлын тухай танилцуулав.

**Д.Долгор:** Даатгалын үйлчилгээнд ухаалаг технологийн хөгжүүлэлтийн танилцуулга хиисэн.

**Р.Жавхлан:** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сангийн порталын хөгжүүлэлтийн тухай танилцуулгыг хийж байхад гишүүдээс горимын санал гаргасан.

**Г.Ганбаяр:** Би санал хэлэх хэрэгтэй байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанд гишүүдийг өөрийн биеэр ирж оролцох чиглэл өгсөн. Өнөөдөр манай боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн болж байгаа. Арга хэмжээнийхээ дундуур ирсэн боловч сайд нараас Эрүүл мэндийн дэд сайд бид 2 л байна, нийт гишүүдийн ирц хүрэхгүй байна. Энэ хурлыг хойшлуулах саналтай байна. Мөн хурлаар танилцуулсан 2 асуудал хоёулаа чухал ач холбогдолтой байх тул хариуцсан яам нь судлаад өөрсдөө танилцуулах шаардлагатай. Гол нь Үндэсний зөвлөлийн гишүүдийн оролцоог хангаж, асуудлаа хэлэлцэж шийдвэрлэх ёстой. Гэтэл дандаа орлож ирсэн хүмүүс оролцоод асуудлаа ярьж шийдвэрлэж болмооргүй байна. Иймд Үндэсний зөвлөлийн хурлыг хойшлуулж, гишүүдийг өөрсдийг нь оролцуулж хуралдуулах саналтай байна. Ингээд миний хувьд 16.00 хүртэл оролцоод яаман дээрх зөвлөгөөндөө очих шаардлагатай болж байгаа тул чөлөө өгөхийг хүсье.

**С.Энхболд:** Г.Ганбаяр дэд сайдтай санал нэг байна. Үндэсний зөвлөл бүрэлдэхүүнээрээ оролцож төлөвлөгөөний тайлан, ирэх оны хийх ажлын төслөө ярих ёстой. Орлож төлөөлж ирсэн хүмүүс асуудлыг шийдвэрлэж болохгүй байх.

**М.Ариунболд:** Энд тавьж байсан итгэлд манай байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээлэл солилцох, ажлаа уялдуулах ажлууд яригдаж байгаа тул гүйцээж сонсоод, цаашдын боломжуудын талаар санал солилцох шаардлагатай байна. Энэ мэдээллийн портол, ухаалаг технологийн хөгжүүлэлт нь хуульд заагдсан сангуудын мэдээллийг нэгдсэн журмаар түргэн шуурхай авч дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой байна. Харин даатгалын Зурагу гэдэг автомашины эвдрэл таньж, үнэлгээ хийх систем нь зөвхөн замын хөдөлгөөний хөдөлгөөний аюулгүй байдлаас гадна замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад ач холбогдолтой гэж үзэж байна. Гэхдээ зарим нэг асуудлаар дахин ярилцаж өөрчлөлт оруулах саналтай байна.

**Ч.Батзориг:** Нийслэлийн Засаг дарга оролцож амжихгүй болсон тул өөртэй нь ярьж, тавих саналын талаар чиглэл авсны дагуу саналуудыг илэрхийлэхээр оролцож байна. Даатгалын ухаалаг технологийн хөгжүүлэлт түгжрэлийг тодорхой хэмжээнд бууруулахад нөлөөлөхөөр байгаа бол Түгжрэлийг бууруулах Үндэсний хороон дээр авч хэлэлцээд тодорхой шийдэл гаргах боломжтой.

**Б.Жамбал:** Өнөөдрийн Үндэсний хороогоор хэлэлцэж буй асуудлууд чухал тул хэт хойшлуулахгүй яаралтай шийдвэрлэх шаардлагатай. Одоо шинэ он дөхөөд, бүгд л тайлан төлөвлөгөө гээд ажил, ачаалал их байгаа тул дахин дахин цуглаад байхад хүндрэлтэй болно. Иймд заавал биеэр гэхгүйгээр дараагийн хурлыг цахимаар ч хийж болно шүү дээ. Болбол 5 дахь өдөр ч хуралдуулахад боломжтой байх. Хурлын хэлэлцэж байгаа асуудлын талаар Амгаланбаатар зөвлөхөд танилцуулья. Ажлын алба бас ЗТХ-ийн сайдтай ярина уу.

**Ё.Жаргалсайхан:** Үндэсний хорооны хуралдаан өмнө нь зайлшгүй шаардлагаар хойшлоод, өнөөдөр хуралдахаар тов зарласан. Нэгэнт гишүүдээс санал тавьж байгаа тул сайдад танилцуулаад хуралдааныг ойрын үед үргэлжлүүлэн хуралдуулахаар яриад, та бүгдэд товыг эргэж мэдэгдье гэснээр хуралдаан завсарлав. Хуралдаанаас

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний Зөвлөлийн хуралдааныг ойрын үед зохион байгуулах
2. Хуралдаанд АХБ-ны "Тээврийн мэдээллийн системийг хөгжүүлэх" техникийн туслалцааны төслийн "Тээврийн ухаалаг систем"-ийн хүрээнд хэрэгжиж байгаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сангийн нэгдсэн цахим портал байгуулах төсөл /ЗХАБҮЗ-ийн 2023 оны төлөвлөгөөний 1.9-д тусгагдсан/-ийн танилцуулгыг ЗТХЯ-наас танилцуулах
3. "Агула даатгал" ХХК-ийн Даатгалын үйлчилгээнд ухаалаг технологийн хөгжүүлэлтийн танилцуулгыг Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хороонд танилцуулахаар болов.

## **“БҮС НУТГИЙН ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ХОЛБОЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ДОЛОО ХОНОГ 2023**

Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулж буй “Бүс нутгийн тээвэр, логистикийн холболтыг бэхжүүлэх нь” Монгол улсын тээврийн долоо хоног 2023 форумын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн үдээс хойшх хуралдаанаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба мэдээллийн нэгдсэн систем” сэдэвт хэлэлцүүлэг боллоо. Тус хуралдаанд доктор (Ph.D) Б.Баярсайхан “Тээврийн салбараас ялгарах хүлэмжийн хийг бууруулахад метанолын үүрэг роль” илтгэлийг, АХБ-ны Авто замын хөрөнгийн менежментийн ахлах мэргэжилтэн Майкл Аняла “Бүсийн авто замын хөгжил ба засвар арчлалтын төслийн 3 дугаар үе шатны танилцуулга: Замын аюулгүй байдал, тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн шийдлүүд”, АХБ-ны тээврийн ахлах мэргэжилтэн Дэйвид Шелтон “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит”, Трансконсалт зөвлөх компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Лауренс Чиу “Тээврийн ухаалаг системийн технологийг ашиглан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь”, Пауэред ХХК-ийн Мэдээллийн Захирал Р.Жавхлан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын веб порталын хөгжүүлэлт” илтгэлийг тавьсан.

Сэдвийн хүрээнд болсон хэлэлцүүлгийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд хөтөлж, Азийн хөгжлийн банкны Авто замын хөрөнгийн менежментийн ахлах мэргэжилтэн Майкл Аняла, Тээврийн цагдаагийн албаны дарга Ц.Ариунболд, ШУТИС-Механик, тээврийн сургуулийн тээврийн салбарын эрхлэгч Доктор (Ph.D), дэд профессор И.Базаррагчаа, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, “Пауэред” ХХК-ийн Мэдээллийн Захирал Р.Жавхлан нартай замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдэх олон улсын сайн туршлага, шийдэл, тээврийн ухаалаг систем болон шинэ технологийг нэвтрүүлэх боломж, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн цуглуулах, боловсруулах, дундын мэдээллийн сан үүсгэх, ашиглах, байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах веб портал хөгжүүлэх асуудлаар сонирхолтой яриа хэлэлцүүлэг өрнүүлж, цаашдын ажлын хөгжүүлэлтэд ач холбогдолтой олон чухал санал санаачлагыг гаргасан онц сонирхолтой арга хэмжээ боллоо.